



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/800

Ховд

Жилийн эцсийн мал тооллого зохион байгуулах,  
хяналт тавих комисс томилох тухай

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1-ийн “в”, “и” заалтууд, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний 208 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал тооллогын ажлыг зохион байгуулах, хяналт тавих аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Т.Жаргалсайхан	-Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Ганболд	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Д.Батцэнгэл	-Мал эмнэлгийн газрын дарга
	Б.Бямбажав	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Ц.Цогтбаяр	-Жаргалант сумын Засаг дарга
	Ч. Багдал	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
	Э.Даваасүрэн	-Аймгийн Цагдаагийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Д.Даваасамбуу -Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга

2. Жилийн эцсийн мал тооллогыг 2020 оны 12 дугаар сарын 15-25-ны хооронд 10 хоногт багтаан үнэн зөв чанартай явуулж дүн мэдээг хугацаанд нь ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мал тооллогын ажлыг зохион байгуулалттай явуулж, хяналт шалгалтыг чанартай хийж, дүн мэдээг хугацаанд нь танилцуулж Үндэсний Статистикийн хороонд тушаахыг комиссын дарга /Т.Жаргалсайхан/, нарийн бичгийн дарга /Д.Даваасамбуу нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/800 Ch  
02 3779